

Төрийн жинхэнэ албан хаагчийг шилжүүлэх, сэлгэн ажиллуулах тухай зар

Админ 2023-12-27 797

Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журмын 4 дүгээр зүйлийн 4.2-т заасны дагуу төрийн өөр байгууллага, нэгж хооронд шилжин ажиллахыг хүссэн төрийн холбогдох бусад байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдыг дараах албан тушаалд холбогдох материалаа цахим шуудангаар ирүүлэхийг урьж байна.

Тавигдах болзол, шаардлага:

- төрийн жинхэнэ албан тушаалд зохих ёсоор томилогдсон байх;
- зарлагдсан албан тушаалтай адил төрөл болон адил ангилалд ажилладаг байх;
- зарлагдсан албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагыг хангасан байх.

Бүрдүүлэх материал:

- Хүсэлт
- Төрийн албан хаагчийн анкет;
- Иргэний үнэмлэхийн хуулбар;
- Боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичиг /диплом/, хэрэв гадаад улсад их, дээд сургууль төгссөн бол боловсролын баримт бичгийн баталгаат орчуулгыг хавсаргах;
- Мэргэшүүлэх сургалтад хамрагдсаныг гэрчлэх баримт бичиг;
- Нийгмийн даатгалын дэвтэр /Хөдөлмөрийн дэвтэр/-ийн хуулбар, цахим лавлагаа;
- Албан тушаалд томилогдсон, чөлөөлөгдсөн тушаал, шийдвэрийн хуулбар;
- Төрийн жинхэнэ албаны тангараг өргөсөн “Тангаргийн хуудас” хуулбар;

- Сүүлийн гурван жилийн төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлсэн илтгэх хуудас, төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээ;
- Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт /e-mongolia–аас татан авах/
- Цэргийн жинхэнэ алба хаах үүрэг хүлээсэн иргэний хувьд цэргийн үүрэгтний үнэмлэх
- Сахилгын шийтгэлтэй эсэх тодорхойлолт
- Төрийн албан хаагчийн ерөнхий болон тусгай шалгалт өгсөн нотлох баримтыг хавсаргах.

Материал хүлээн авах:

- Хугацаа: 2024 оны 01 дүгээр сарын 05 -ны өдрийн 17.00 цаг хүртэл
- Хүлээн авах хаяг: Жагсаалтад бүртгэлтэй тухайн байгууллагын цахим шуудангаар бичиг баримтаа бүрэн бүрдүүлэн илгээнэ.
- Эрүүл мэндийн газар: narandarig@gmail.com Холбоо барих утас 99891343
- Нийгмийн даатгалын хэлтэс: orhon@ndaatgal.mn Холбоо барих утас: 99262089
- Хөдөлмөр халамж үйлчилгээний газар: hhug.orkhon@gmail.com Холбоо барих утас: 99999148
- Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар :orkhon@gazar.gov.mn Холбоо барих утас: 99903884

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ТУШААЛД ШИЛЖҮҮЛЭН АВАХ АЖЛЫН БАЙРНЫ ЖАГСААЛТ

									дугаар тогтоолсор өөрчлөлт оруулсан!	тогтоолоор өөрчлөн найруулсан!
6	Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс	Үйлчилгээний тасаг	Бичиг хэрэг, хүний нөөц, дотоод асуудал хариуцсан мэргэжилтэн		Гүйцэтгэх	ТЗ-9	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй	-Эрх зүй /042/ -Багш мэргэжлийн /0114/ -Менежмент ба удирдахуй /041301-041304/ -Эдийн засаг /03110201/ -Нягтлан бодох бүртгэл /041101/ - Санхүү, банк, даатгал /0412/	"Төрийн албаны богино болон дунд хугацааны сургалтад хамрагдаж төгссөн байх" гэснийг хассугай. <i>/Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 03 дугаар сарын 21-ны өдрийн 90 дугаар тогтоолсор өөрчлөлт оруулсан!</i>	Туслах түшмэлийн албан тушаалд 2-оос доошгүй жил ажилласан бол давуу тал болно.
7	Газрын харилцаа, хот байгуулалтын газар	Газрын удирдлагын хэлтэс	Геодези, зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн	1	Төрийн захиргаа	ТЗ-9	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй	Геодези	"Төрийн албаны богино болон дунд хугацааны сургалтад хамрагдаж төгссөн байх" гэснийг хассугай. <i>/Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 03 дугаар сарын 21-ны өдрийн 90 дугаар тогтоолсор өөрчлөлт оруулсан!</i>	Туслах түшмэл болон түүнээс дээш ангиллын албан тушаалд эсхүл мэргэжлээрээ 1-ээс доошгүй жил ажилласан байх
8	Хяналт шалгалтын хэлтэс	Хяналт шалгалтын хэлтэс	Усан хангамж, ариутгах татуургын хяналтын улсын байцаагч	1	Төрийн захиргаа	ТЗ-7	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй	- Иргэний ба үйлдвэрийн барилга байгууламж (0732) -Цахилгаан, эрчим хүч (0713)	"Төрийн албаны богино болон дунд хугацааны сургалтад хамрагдаж төгссөн байх" гэснийг хассугай. <i>/Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 03 дугаар сарын 21-ны өдрийн 90 дугаар тогтоолсор өөрчлөлт оруулсан!</i>	Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ОРХОН АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛ